

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 2023/02

Улаанбаатар хот

## Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.12 дахь, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.5.6 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хот, суурин газрын инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын чанар, ашиглалтын төлөв байдалд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд ашиглагдаж байгаа 260.06 км, шинээр баригдаж буй 40.85 км үерийн хамгаалалтын барилга байгууламжууд хамрагдахад 18 аймгийн 139 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээс инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөлгүй байгаа нь тогтоогдсон.

Үүнээс шалтгаалж төлөвлөлтгүйгээр суурьшлын бүсийг тэлж үерийн аюултай голын сав газрын хамгаалалтын бүсэд 6020 иргэн, 1309 аж ахуйн нэгж байгууллагад газар олгосон, 303 иргэн, 63 аж ахуйн нэгж байгууллагууд зөвшөөрөлгүй суурьшсан, 336 иргэн, 618 аж ахуйн нэгж байгууллагууд барилга барьсан, Улаанбаатар хотын 3, 4 дүгээр хорооллын далан, Дэнжийн 1000, Зайсангийн баруун уулын үерийн хамгаалалтын суваг, зүүн уулын үерээс хамгаалах байгууламж 1-4, Бэлхийн далан, Хайлаастын болон намгийн суваг, Телевизийн тунгаагуур, Сэлбэ, Туул, Дунд, Улиастайн голын үерийн хамгаалалтын зурвас алдагдсан зэрэг зөрчлүүд гарсан байна.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн усархаг борооны улмаас хөрсний усны түвшин дээшилж барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай усанд автах, хөрсний суулт, барилга байгууламжийн суурийн хийц бүтээц, бат бэх, тогтвортой байдалд нөлөөлөх, хүн ажиллаж амьдрах боломжгүй нөхцөл үүсэх, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрах эрсдэлтэй байна.

Иймд Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.12, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.5.6 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах, уруйн үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот

байгуулалтын газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Геодези, усны барилга байгууламжийн газрын дарга нарт ДААЛГАХ нь:

1.Уруйн үерээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллах. Үүнд:

1.1.хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байгаа сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар яаралтай хийлгэж, батлуулах, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

1.2.хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, гидрологи болон гидрогеологийн тайлан судалгаа дээр үндэслэн инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламжийг шинээр барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах;

1.3.хот, суурин газрын үерийн аюултай бүс болон үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зурваст зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй суурьшсан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжийн судалгааг гаргаж, аюултай бүсээс нүүлгэн шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттай зохион байгуулах;

1.4.хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн бэлтгэл ажил, үерийн усны шугам сүлжээнд хамгаалалтын бүс тогтоож, шинээр газар олгож суурьшлын бүсийг шинээр үүсгэхгүй байх;

1.5.хот, суурин газрын үерт автаж болзошгүй хүн олноор төвлөрсөн газруудыг тодорхойлж тогтоох, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний суваг, худгуудыг үерийн усанд автахаас урьдчилан сэргийлж үерийн усны гадаргын урсацыг цуглуулах, зайлуулах арга хэмжээг авах;

1.6.хот, суурин газрын үерийн ус зайлуулах байгууламж, шугам сүлжээний ашиглалтын чанар, төлөв байдлыг тогтоох, паспортжуулалтыг хийх, засвар шинэчлэлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлж, геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан болон хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, баяжилтыг тогтмол хийх;

1.7.үерийн хамгаалалтын далан суваг, авто замын борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээ, өргөлтийн насос станц, газар доорх усны мониторингийн цооног, түүний барилга байгууламжийн засвар ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах байгууллагыг тодорхой болгох, түүнд тавих хяналтыг сайжруулж, заавар зөвлөмж өгөх, эвдрэл гэмтлийн үед шуурхай арга хэмжээ авч, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангуулах;

1.8.байгалийн гамшиг, үер усны зэрэг аюулт үзэгдэл, үйлдвэрлэлийн ослын үед барилга байгууламжид эвдрэл, гэмтэл гарсан эсэхийг илрүүлэн арилгах

зорилгоор техникийн үзлэг шалгалтыг зохион байгуулж, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг тухай бүр хийж гүйцэтгэх;

1.9.хот суурин газрын үерээс хамгаалах далан, суваг, ус зайлуулах байгууламжийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, шаардлагатай хэсгүүдийг сэргээн засварлах, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

1.10.орон нутгийн чанартай авто замд үзлэг шалгалтыг норм дүрмийн дагуу хийж, авто замын зурвас газар, гүүр, хоолойн хэсэгт байгаа хог хаягдал, малын сэг зэм, хатуу болон зөөлөн материалын хаягдлыг цэвэрлэх, гол горхины урсгал гольдролыг чиглүүлэн засах, урсгал залах далан, шуудууг сэргээн засварлах, хөрс угаагдалтанд орох эрсдэлтэй бүсэд хамгаалах арга хэмжээг авч, хаврын шар ус, үерийн ус урсан өнгөрсний дараа ус зайлуулах шуудуу, хиймэл байгууламжид тогтсон хог хаягдлыг дахин цэвэрлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих;

1.11.уулын ам, гол усны ойр суурьшиж байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үерийн далан, борооны ус зайлуулах суваг, шуудуу, голын голдролыг өөрчлөхгүй байх, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, гол, мөрний орчимд тоглуулахгүй байх, зөвшөөрөгдсөн зам гүүрээс өөр гарц гармаар зорчихгүй байхыг анхааруулах.

2.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Геодези, усны барилга байгууламжийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3.Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Магнайсүрэн)-д даалгасугай.

САЙД  Ц.ДАВААСҮРЭН